



ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛ, ОЛОН НИЙТИЙН САНАА БОДОЛ

Социологийн шинжилгээ



Агуулга

Шинжилгээний арга зүй.....	2
1. Монгол Улсын Шинжлэх ухааны академийн судалгаа (2005-2013 он)	2
2. Нээлттэй нийгэм форум, Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн	5
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ын харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судалгаа (2013 он).....	7
4. Дэлхийн банк, Авлигатай тэмцэх газрын Засаглалыг дэмжих төсөл судалгаа (2009 он)	8
5. “Азийн сан”, “Сант Марал” сангийн “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа” (2010-2015 он).....	9
6. “Азийн барометр” Олон улсын ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа (2003-2010 он) 10	
7. Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын судалгаа (2008-2014 он)	11
8. Транспэрэнси интернэшнл байгууллагын авлигын индексийн судалгаа (Transparency International–Corruption Perception Index)	13
9. Эрх зүйт ёс ба авлигаас ангид байх үзүүлэлт (Heritage foundation) судалгаа	14
10. Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн судалгаа (2014 он)	15
11. Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаа	15
12. “Хөгжлийн эрэлд” судалгааны байгууллагын “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” социологийн судалгаа.....	16
13. “Монгол Улсын Шүүхийн байгууллагад хийсэн судалгаа /Judicial Integrity Scan/ ГОУХАН /GIZ/-аас хийсэн тайлан”	17
14. “Транспэрэнси интернэшнл” олон улсын байгууллагаас хийсэн 2017 оны авлигын төсөөллийн индексийг танилцуулсан байдал	18
15. “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга байдлын судалгаа- шүүхийн байгууллагын тайлан” ШЕЗ, УЕПГ, ХЗДХЯ, МХХ хамтран баталсан удирдамжийн дагуу Азийн сангаас явуулсан судалгааны тайлан (2018.10 сар).....	19
16. “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгааны тайлан (2017-2019 он)	29
ДҮГНЭЛТ	31

Шинжилгээний арга зүй

Энэхүү шинжилгээнд Монгол Улс дахь шүүх эрх мэдлийн байгууллагад иргэдийн өгч буй үнэлгээ, шүүхийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлаар олон нийтийн санаа бодлыг судалсан зарим судалгааны үр дүнг товч танилцуулж байна.

Иргэд, олон нийтийн санаа бодлыг судлах чиглэлээр 2003-2019 онд санал асуулгын судалгаа явуулсан ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Ерөнхийлөгчийн тамгын газрын дэргэдэх Үндэсний хөгжлийн хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Авлигатай тэмцэх газар, Сант марал сан, Нээлттэй нийгэм форум, УТБА-ийн “Азийн Барометр” төсөл, Дэлхийн банк, АТГ-ын Засаглалыг дэмжих хөтөлбөр, Херитэйж фаундэйшн (Heritage foundation), The Wall Street сэтгүүл хамтран гаргасан эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт, Транспэренси интернэшнл, ГОУХАН /GIZ/, Азийн сан зэрэг судалгааны байгууллагын мэдээллийг ашиглав.

1. Монгол Улсын Шинжлэх ухааны академийн судалгаа (2005-2013 он)

Монгол улсын Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Ардчилсан засаглалыг бэхжүүлэх төслүүд хамтран 2005-2013 онд ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт, ардчиллын хөгжил, төлөвшлийн явцын талаар 4 удаагийн давтамжит судалгаа явуулсан бөгөөд уг судалгаанд хууль дээдлэх ёс, шүүхийн хүртээмжтэй байдлын талаар судалсан байна.

1.1 Шүүх, шүүхийн тогтолцоо гүйцэтгэх засаглалаас хэр зэрэг хараат бус байж, бүх төрлийн хөндлөнгийн нөлөөнөөс хэр зэрэг ангид байж чаддаг вэ?

Монгол дахь засаглалын төлөв байдлыг үнэлэх 2006 оны судалгаагаар “Шүүхийн хараат бус байдлыг практик дээр зохицуулдаг дүрэм журам хангалттай түвшинд үйлчилдэггүй, эрх зүйт төрд шаардлагатай соёл улс төрийн хүрээнд төлөвшөөгүй, шүүгчдийн дээд түвшний томилгоо улс төрийн шалгуураар хэмжигддэг, шүүхийн зардлыг төсөвт 0.45 хувь орчимд тооцон суулгаж байгаа нь шүүх, шүүгчдийн орон байр, цалин, томилолт, холбоо харилцаа, шүүн таслах үйл ажиллагаанд хүрэлцдэггүй зэрэг нь шүүхийг улс төрөөс зарим талаар хараат болгож байна. ...Засгийн газар хууль тогтоох эрх мэдэл дэх нөлөө, бодлого дангаар тодорхойлж буй боломжоо ашиглан хуулиар шүүхийн хараат бус байдалд халдах явдал гарч байна”¹ гэж үнэлсэн байна.

1.2 Шүүх тогтолцоо нь шударга, үр дүнтэй үйлчилгээ үзүүлдэг гэдэгт хүмүүс хэр зэрэг итгэлтэй байдаг вэ?

Санал асуулгад оролцсон иргэдийн 64.5 хувь нь “Шүүх төр иргэний хоорондын маргааныг шийдвэрлэхдээ төрийн эрх ашгийн хувь хүнийхээс илүүд үздэг гэж хариулсан байна. Мөн тус судалгаагаар асуудлыг шүүхээр шийдүүлэхэд зардал чирэгдэл ихтэй гэж 30 хувь нь хариулсан бол 83.9 хувь нь “Шүүх хөрөнгө мөнгө, эрх мэдэлтэй хүмүүс, танил

¹ Монгол улсын Гадаад хэргийн яам, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, “Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын тавдугаар бага хурал”-ын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл. “Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ” Улаанбаатар 2006 он. 25 дахь тал

талдаа үйлчилдэг, 70.1 хувь нь шүүхийн шийдвэрт төрийн албан тушаалтнууд, улс төрчид нөлөөлдөг, шүүхийн шийдвэрийг завхруулж болдог гэж 50.8 хувь нь хариулсан байна. Хуулийн ажилтан (өмгөөлөгч, прокурор, шүүгч) 475 хүн, 417 үйлчлүүлэгчийн дунд явуулсан судалгаагаар хуулийн мэргэжлийн хүмүүсийн 55.3 хувь нь, иргэдийн 73.8 хувь нь хууль сахиулагчид хээл хахууль авч байсан гэж хариулжээ².

Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлтийн талаар 2008 онд явагдсан судалгаанаас үзвэл Хууль, шүүхийн байгууллагаар асуудлаа шийдүүлэхэд танил талгүй бол бүтэхгүй гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 28 хувь нь хариулсан бөгөөд цаг их авдаг, хүнд суртал ихтэй, зэрэг бэршээл байгааг нэрлэсэн байна. Шүүхийн шийдвэрт албан тушаалтан нөлөөлдөг гэж 2005 онд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 68 хувь нь үзэж байсан бол 2008 онд 75 хувь болж өссөн байна.

Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлтийг үнэлэх судалгааны хүрээнд хийсэн олон нийтийн санаа бодлын судалгааны дүнгээс харахад иргэд шүүх хөрөнгө мөнгө, эрх мэдэлтэйд илүү үйлчилдэг (45.4%), шүүхийн шийдвэрт албан тушаалтнууд нөлөөлдөг (41.2%), төрийн эрх ашигт үйлчилдэг (47.7%) гэсэн хариултууд зонхилж байна. Эндээс харахад шүүхийн тогтолцоо нь шударга, үр дүнтэй үйлчилгээ үзүүлдэг гэдэгт итгэх жирийн иргэдийн итгэл нилээд буурч байгааг харуулж байна³.

Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлтийг үнэлэх 2010 оны судалгаанд Шүүх эрх мэдлийн хараат бус байдал нь төсөв мөнгөний хүрэлцээ, шүүгчдийн цалин, орлого бусад хангамжийн асуудал шууд холбогддог. Үндсэн хуулинд Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана (48 дугаар зүйл) гэж заасан боловч шүүхийн төсвийн төслийн батлах үйл явц Сангийн яамнаас шууд хараат байдлаар явж ирсэн. Улсын төсөвт шүүхийн нийт төсвийн эзлэх хувь маш бага байна. 2005-2010 онуудад жилд дунджаар 0.40-0.48 хувийг нь шүүхийн төсөв эзэлж байна. Монгол улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн судалгаанаас үзэхэд гол төлөв шүүгчдийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын эдийн засгийн баталгааг хангаж хэрэгжүүлэх болон дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлж хэрэгжүүлэх арга хэмжээ тасалдсан байгаа нь эдийн засгийн хараат байдлыг харуулж байна⁴ гэж үнэлсэн байна.

Монголчуудын дөнгөж 28 хувь нь шүүхэд хандсан тохиолдолд асуудлаа шударгаар шийдүүлж чадна гэж итгэдэг. Гэтэл үүний эсрэгээр 85 хувь нь шүүх хөрөнгө чинээ, төрийн албан тушаал, садан төрлийн болон найз нөхдийн холбоо, компаниуд, хувь хүн үү гэдгийг харж шийдвэр гаргадаг гэж үзжээ⁵.

² Монгол улсын Гадаад хэргийн яам, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, “Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын тавдугаар бага хурал”-ын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл. “Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ” Улаанбаатар 2006 он. 30 дахь тал

³ ШУА-ийн ФСЭХ, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, “МЗХ 9 хүний эрх, Ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд” дэмжлэг үзүүлэх төсөл. “Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2007-2008” Улаанбаатар 2008 он. 17-19 дэх тал

⁴ ШУА-ийн ФСЭХ, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, “МЗХ 9 хүний эрх, Ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд” дэмжлэг үзүүлэх төсөл. “Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2009-2010” Улаанбаатар 2010 он. 19 дэх тал

⁵ Мөн тэнд

Шүүхийн талаар олон нийтийн санал асуулгаас үзвэл шүүхийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэхэд танил талгүй бол бүтэхгүй (16.6 хувь), хүнд суртал (16.0 хувь), зардал чирэгдэл их (15.1 хувь), цаг их авдаг(13.2 хувь), авлига авах гээд байдаг (11.6 хувь) гэсэн бэршээлүүд илүү тохиолддог гэж хариулжээ⁶. 2005-2010 оны судалгаанаас үзвэл хүнд суртал, авлига, асуудлыг шударга шийдвэрлэж чаддаггүй гэсэн хариултын эзлэх хувь өссөн байна. /Хүснэгт 1.1/

№	Хариулт	Хүснэгт 1.1		
		2005 он	2008 он	2010 он
1	Танил талгүй бол бүтэхгүй	28.0	18.2	16.6
2	Хүнд суртал ихтэй	-	7.0	16.0
3	Зардал чирэгдэл их	20.9	12.3	15.1
4	Цаг их авдаг	13.2	5.2	13.2
5	Авлига авах гээд байдаг	0.1	3.5	11.6
6	Асуудлыг шударгаар шийдвэрлэж чаддаггүй	-	-	9.7
7	Асуудлыг шударгаар шийдвэрлэж чадна гэдэгт итгэдэггүй	1.0	4.1	-

ШУА-ын ФСЭХ-ийн судлаачид 2005-2010 онд явагдсан судалгаанаас үзвэл олон нийтийн үнэлгээнд эерэг хариулт гараагүй, бүхэлдээ шүүхийн талаар дээрх хандлагуудыг зөвшөөрч буй хүмүүсийн тоо өссөн, харин санал нийлэхгүй байгаа хувь буурсан байгаагаас үзэхэд иргэдийн шүүхэд итгэх итгэл улам бүр алдагдаж байна⁷ гэж дүгнэсэн байна.

Монголын ардчиллын үнэлгээ, ардчиллын хөгжил, төлөвшлийн явцын талаарх олон нийтийн санаа бодлын талаарх 2013 оны судалгаанаас үзвэл иргэд хууль, шүүхийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэхэд танил талгүй бол бүтэхгүй гэж хариулсан (17.3 хувь)-тай дараагаар нь танил талгүйгээс болоод илүү их цаг зарцуулдаг гэж хариулсан (16.9 хувь)-тай байгаа бөгөөд ерөнхийдөө цаг зарцуулалтаас шалтгаалан зардал чирэгдэл их тулгардаг гэсэн санаа бодлыг илэрхийлсэн байна. Энэ нь хүмүүсийн дунд хуулиас гадуур өөрт тулгарсан асуудлаа шийдэж байгааг харуулж байна. Хэдий тийм боловч 2010 оны судалгааны дүнтэй харьцуулахад шүүх, хууль сахиулах байгууллагуудын үйлчилгээнд ямар нэгэн хэмжээгээр ахиц гарсан гэж судалгаанд оролцогчдын олонх нь үзэх болжээ⁸.

Мөн тус судалгаагаар шүүхийн дунд дэлгэрсэн сөрөг үзэгдэлд авлига хээл хахууль нэмэгдсэнтэй холбоотой гэж хариулсан хувь хамгийн их буюу 25.1 хувь байгаа нь энэ хүрээнд авлигын сүлжээ багасахгүй байгаагийн илэрхийлэл юм. Иргэдийн боловсрол хангалтгүй гэж үзсэн хүмүүс 14.9 хувь байгаа нь иргэдийн эрх зүйн боловсрол сайнгүй, хууль шүүхийн талаар мэдлэг мэдээлэл дутмаг, хүртээмж муу байдгийг харуулж байна.

⁶ ШУА-ийн ФСЭХ, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, “МЗХ 9 хүний эрх, Ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд” дэмжлэг үзүүлэх төсөл. “Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2009-2010” Улаанбаатар 2010 он. 23-25 дахь тал

⁷ Мөн тэнд

⁸ ШУА-ийн ФСЭХ, Төрийн бодлогын шинжилгээний хүрээлэн ТББ, Монголын ардчиллын үнэлгээ, ардчиллын хөгжил, төлөвшлийн явцын талаарх олон нийтийн санаа бодол. Улаанбаатар 2013 он. 27 дахь тал

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд сүүлийн үед хийгдэж буй өөрчлөлтүүдийн талаар үнэлгээнд 2.5 хувь нь “сайн мэднэ”, 14.7 хувь нь “Ерөнхийдөө мэднэ”, 39.8 хувь нь “Дуулсан сайн мэдэхгүй”, 43 хувь нь “Ер нь мэдэхгүй юм байна” гэж хариулсан байна. Шүүхийн шинэчлэлтийн хүрээнд хийгдэж буй ажлуудын талаар иргэд ерөнхийдөө хариулж мэдэхгүй байна. Ард иргэдийн дунд шүүхийн шинэчлэлтийн хүрээнд хийгдэж буй ажлуудыг хүртээмжтэй байдлаар хүргэх хэрэгтэй байгааг тус тайланд дурдсан байна.

Шүүхийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлыг давтамжит судалгааны дүнгүүдээс харьцуулсан үнэлгээний дунджаас харвал шүүхийн шийдвэрт албан тушаалтан нөлөөлдөг тухай 2005 онд 1.67 хувь, 2008 онд 1.66 хувь, 2010 онд 2.41 хувь, 2013 онд 2.33 хувь болж 2005 оноос 0.66 хувиар нэмэгдсэн дүр зураг ажиглагдаж байна. Хэдийгээр иргэдийн зүгээс энэ асуудалд “маш муу” гэсэн үнэлгээ өгч байсан ч сүүлийн үед хийгдэж байгаа зарим үйл ажиллагаа нь иргэдэд эргэлзэх, хүлээнэх хандлагыг төрүүлж байгааг харж болохоор байна⁹.

Шинжлэх ухааны академийн судалгааг бүхэлд нь дүгнэвэл 2005-2010 он хүртэлх судалгаанд оролцсон иргэд шүүхийн байгууллагын талаар сөрөг сэтгэгдэлтэй, шүүхэд итгэх иргэдийн итгэл буурсан үзүүлэлттэй гарсан байна. 2013 оны судалгаагаар шүүхийн нэр хүнд муу талдаа гарсан боловч шүүхийн шинэчлэлтэй холбоотой зарим үзүүлэлтүүд эерэг дүнтэй, шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд хүлээцтэй хандах дүр зураг ажиглагдаж байна.

2. Нээлттэй нийгэм форум. Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа (2008 он)

Нээлттэй нийгэм форумын захиалгаар 2008 онд АНУ-ын Аризонагийн их сургуулийн хуулийн профессор Brent Вайт /Brent T. White/-ын гүйцэтгэсэн Монгол улсын шүүхийн шинэтгэлийн нөхцөл байдлыг үнэлэх судалгаа нь шүүхийн үйл ажиллагааг 11 үзүүлэлт бүхий индикатор гарган шүүхийн тогтолцооны талаар нарийн мэдэх шүүгчид, өмгөөлөгчид, сэтгүүлчид, гадны ажиглагчдыг хамарсан түүвэр бүлгээс 30 мэргэжилтнийг оролцуулан санал асуулга авч, 60 хүчин зүйл тус бүрээр шүүхийг үнэлсэн байна.

Шүүхийн шинэтгэлийн индексийг категоруудад хуваан тус бүрт нь ерөнхий үнэлгээ буюу “Онц сайн”, “Хангалттай”, “Ялимгүй хангалттай”, “Хангалтгүй”, “Огт хангалтгүй” гэсэн дүгнэлт гаргасан байна. Монгол улсын шүүх тус 11 үзүүлэлтээс 1 үзүүлэлтээр “Ялимгүй хангалттай”, бусад 10 үзүүлэлтээр “Хангалтгүй” гэсэн дүнтэй гарсан байна.

Тус судалгааны зарим үр дүнг дурдвал судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн 66 хувь нь шүүгчид суурь мэргэжлийн хувьд сайн бэлтгэгдсэн байдаг гэдэгтэй санал нийлээгүй ба 57 хувь нь шүүгчид ажилд томилогдохоос өмнө хангалттай сургалтанд хамрагддаггүй гэж үзсэн байна.

⁹ ШУА-ийн ФСЭХ, Төрийн бодлогын шинжилгээний хүрээлэн ТББ, Монголын ардчиллын үнэлгээ, ардчиллын хөгжил, төлөвшлийн явцын талаарх олон нийтийн санаа бодол. Улаанбаатар 2013 он. 29 дэх тал

Төрийн эрх мэдлийн бусад салаа мөчир нь шүүхийн шийдвэрийг хүндэтгэж, албадан биелүүлдэг гэдэгтэй 50 хувь нь санал нийлэхгүй, 32 хувь нь санал нийлнэ, 18 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Шүүхийн нийт төсөв нь шүүхээр үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангахуйц түвшинд байдаг гэдэгтэй 33 хувь нь санал нийлэхгүй, 29 хувь нь санал нийлнэ, 28 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Шүүхийн байр нь шударга ёсыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц бүхий хүндэтгэл төрүүлэхуйц орчин бүрдсэн байдаг гэдэгтэй 63 хувь нь санал нийлэхгүй гэж хариулсан байна.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангалттай түвшинд хамгаалдаг гэдэгтэй 55 хувь нь санал нийлэхгүй, 14 хувь нь санал нийлнэ, 32 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Шүүхийн шийдвэрт төрийн эрх мэдлийн бусад салаа мөчир хийгээд бусад төрийн албан тушаалтны зүгээс нөлөөлөх явдал гардаггүй гэдэгтэй 43 хувь нь санал нийлэхгүй, 19 хувь нь санал нийлнэ, 38 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг сонгосон байна.

Шүүхийн шийдвэр нь хэргийн зохигчид эсвэл бусад сонирхогч талаас өгсөн төлбөр, бэлэг, сэлтийн нөлөөнд ордоггүй гэдэгтэй 77 хувь нь санал нийлэхгүй, 23 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол санал нийлнэ гэж хариулсан хүн байхгүй байна. Шүүгч шийдвэр гаргахдаа ямар нэгэн зүй бус нөлөөнд автдаггүй” гэдэгтэй 77 хувь нь санал нийлэхгүй байна.

Тус судалгаагаар шүүгчийн цалинг 1000-3000 долларын хооронд шүүгчийн цалинг хөдөлмөр, зүтгэлээр нь тогтоож байх, хуулиар шүүгчийн цалинг зүй бус үйлдэл гаргасан үндэслэлээр үндсэн цалинг нь бууруулахаас бусад ямар ч тохиолдолд багасгахгүй байх, шүүгчийн цалин хамгийн шилдэг хүмүүсийг татахуйц байх, шүүгч авлигад автан ажлаа эрсдэлд орохоос зайлсхийж байх ёстой

Судалгаанд хамрагдсан мэргэжилтний 82 хувь нь шүүгчид үнэхээр хэргийн талууд болон тэдний өмгөөлөгчтэй хувиараа үулзах явдал байдаг гэдэгтэй санал нийлжээ. Ганцаарчлан уулзахдаа ямар асуудал ярьдаг эсэхээс үл хамааран ийм үйлдэл нь авлигад өртөх нөхцлийг бүрдүүлж, шүүхийг хардахад хүргэж байна. Шүүгчийн зүй бус үйлдлийн талаар гарсан гомдлыг бүрэн дүүрэн мөрдөж шалгадаг гэдэгтэй 46 хувь нь санал нийлэхгүй байна, 23 хувь нь санал нийлж байна, 31 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан байна.

Шүүхээр үйлчлүүлэгчид хэргийнхээ явцын талаар мэдээлэл олж авахад төвөггүй байдаг гэдэгтэй 82 хувь нь санал нийлэхгүй байна, 9 хувь нь санал нийлж байна, 9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Шүүх хурлын танхим нь иргэд, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг багтаах зайтай байдаг гэдэгтэй 82 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан байна.

Шүүхийн тогтолцоонд хэргийг боломжийн хугацаанд шуурхай шийдэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд хэргийг хүлээн авч бүртгэх, хэргийн явцыг хянах үр дүнтэй, хүртээмжтэй тогтолцоо үйлчилдэг гэдэгтэй 50 хувь нь санал нийлэхгүй, 27 хувь нь санал нийлнэ, 23 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Шүүгч процессийн хэм хэмжээг дагаж мөрдөн, албадан

биелүүлдэг гэдэгтэй 68 хувь нь санал нийлэхгүй байна, 14 хувь нь санал нийлж байна, 18 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан байна.

Зуучлал, арбитр зэрэг маргаан шийдвэрлэх шүүхийн бус арга хэлбэр бий болж хэвшсэн бөгөөд шүүхээс гадуур хэрэг маргааныг шийдвэрлэх найдвартай боломж олгодог гэдэгтэй 54 хувь нь санал нийлэхгүй байна, 23 хувь нь санал нийлж байна, 13 хувь нь мэдэхгүй гэж тус тус хариулсан байна¹⁰.

Монгол улсын шүүхийн шинэтгэлийн явцын талаар 2008 онд гүйцэтгэсэн тус судалгаагаар шүүхийн шинэтгэлийн үйл явц хангалтгүй үнэлгээ авсан байна.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ын харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судалгаа (2013 он)


Тус хүрээлэнгээс 2013 оны 5 дугаар сард “Нийгэм эдийн засгийн өнөөгийн байдлын тухай иргэдийн санаа бодол” сэдэвтэй санал асуулга судалгаа явуулж 1690 хүнийг хамруулсан байна.

Энэхүү судалгаагаар Монгол улс ойрын ирээдүйд ямар асуудалд хамгийн их анхаарч ажиллах ёстой вэ? гэсэн асуултанд “Шүүх засаглалыг шинэчилж, шударга ёсыг тогтоох” гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 41 хувь нь хариулсан ба хамгийн чухал гэсэн 11 асуудлаас хоёрдугаарт орсон байна¹¹. /График 3.1/

График 3.1

Оролцогчдын үзэж буйгаар ойрын ирээдүйд хамгийн их анхаарах асуудлууд (хаалттай хэлбэрээр асуусан асуулт)¹

Авилгал, хээл хахуулийг багасгах	59.84
Шүүх засаглалыг шинэчилж, шударга ёсыг тогтоох	41.01
Байгалиа хамгаалж, үүл үүрхэйн ашиглалтыг багасгах	29.41
Улс төрийн нам бүлэглэлийн талцал, ашиг сонирхлыг хязгаарлах	28.32
Мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэж, боловсролыг чанаржуулах	25.30
Хот сүүрингийн төлөвлөлт дэд бүтцийг сайжруулах	23.33
Гадны биш, орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих	24.14
Хувийн хэвшилд ирэх дарамт шахалтыг багасгах	19.87
Бизнесийн зорилгоор жижиг зээл авах эрхийг иргэдэд олгох	15.92
Төрийн албан хаагчаар мэдлэг, чадвартай хүмүүсийг ажиллуулах	14.16
Үрэлгэн хэрэглээ, хүч тарамдсан хөрөнгийн хуваарилалтыг зогсоох	12.56



¹⁰ Нээлттэй нийгэм форум. Монгол улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан. Улаанбаатар. 2009 он, 7-25 дахь тал

¹¹ <http://www.scribd.com/doc/237381216>

Мөн тус судалгаагаар төрийн байгууллагын үйлчилгээний талаар иргэдийн санаа бодлыг судалсан бөгөөд хамгийн муу үйлчилгээ үзүүлдэг байгууллага юу вэ? гэсэн асуултанд 30.3 хувь нь “Шүүх” гэж хариулсан нь хамгийн муу үйлчилгээ үзүүлдэг гэсэн байгууллага дотор 3 дугаарт орж байна. Эсрэгээр хамгийн сайн үйлчилгээ үзүүлдэг байгууллага гэсэн ангилалд хамгийн сүүлийн байранд шүүх байгууллага гэж хариулсан бөгөөд судалгаанд хамрагдсан иргэдийн 4.57 хувийн санал авсан байна¹². Тус судалгааны тайланд Монгол улсад хамгийн тулгамдаж буй асуудалд “Авлига хээл хахуулийг багасгах”, “Шүүх, прокурорыг ил тод, шударга ажилладаг болгох” зэргийг чухалчлан дурдсан байна.

4. Дэлхийн банк, Авлигатай тэмцэх газрын Засаглалыг дэмжих төсөл судалгаа (2009 он)

Дэлхийн банк, Авлигатай тэмцэх газраас “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх” туршилт судалгааг 2009 онд төрийн 30 байгууллага болон төрийн үйлчилгээ авсан 300 респондентыг хамруулан санамсаргүй түүвэрлэлтээр санал асуулга судалгаа авсан байна.

Тус судалгаанд оролцсон иргэдийн өгсөн үнэлгээгээр “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллага” шударга байдлын үнэлгээгээр хамгийн өндөр үнэлгээ буюу 63.9 гэсэн үнэлгээ авсан бол “Шүүх байгууллага” 39.2 гэсэн үнэлгээ авсан бөгөөд 12 байгууллагаас 10 дугаар байранд орсон байна. Дундаж үнэлгээнээс харьцангуй доогуур байна. /Хүснэгт 4.1/

<i>Хүснэгт 4.1</i>		
№	Байгууллага	Үнэлгээ
1.	Хөдөлмөр, халамж үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллага	63.9
2.	Ерөнхий боловсролын байгууллага	61.1
3.	Эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага	59.8
4.	Баг, хорооны засаг даргын ажлын алба	57.4
5.	Дээд боловсролын байгууллага	56.6
6.	Иргэний бүртгэл мэдээллийн байгууллага	54.9
7.	Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллага	53.5
8.	Аймаг, нийслэлийн засаг даргын тамгы н газар	53.3
9.	Сум, дүүргийн засаг даргын тамгын газар	47.4
10.	Шүүх	39.2
11.	Цагдаагийн байгууллага	32.9
12.	Газрын алба	25.9
13.	Дундаж үнэлгээ	50.5

¹² Мөн тэнд

Төрийн байгууллагууд иргэдэд үйлчлэхдээ хөшүүн хойрго ханддаг уу? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэд газрын алба (63.4%), цагдаа (52.9%), шүүх (44.4%) байгууллагыг сөрөг үнэлсэн бол судалгаанд хамрагдсан байгууллагууд газрын алба (81.2%), шүүх (62.5%), цагдаа (52.6%) зэргийг тус бүр нэрлэжээ¹³. Тус судалгаанд хамрагдсан иргэд болон байгууллагууд аль аль нь шүүх байгууллагыг үйлчилгээ муу үзүүлж байна гэсэн үнэлгээ өгсөн байна.

Дээрх судалгаанаас үзэхэд шүүхийн байгууллагын үйл ажиллагааг 2009 онд иргэд харьцангуй доогуур үнэлсэн байна.

5. “Азийн сан”, “Сант Марал” сангийн “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа” (2010-2015 он)

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Азийн сан, Сант марал сангаас Монгол улсад засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2014 оны 3 дугаар сард Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгааг гүйцэтгэсэн байна.

График 5.1



Тус судалгаанаас үзвэл шүүхийн байгууллагын шударга үйлчилгээний хандлагыг үнэлүүлсэн бөгөөд 2010 онд 25.8 хувь нь “шударга” гэж хариулж байсан бол 2012 онд 25.5 хувь, 2013 онд 30.1 хувь нь 2014 онд 29.9 хувь нь шударга үйлчилгээ үзүүлж байна гэж хариулсан байна¹⁴. /График 5.1/ 2014 онд шударга үйлчилдэг гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь ялимгүй буурсан боловч 2010 онтой харьцуулахад харьцангуй өндөр байна. Бүхэлдээ шударга үйлчилдэг гэсэн хариулт өгсөн хүний тоо сүүлийн жилүүдэд өссөн байна. (2010 онд судалгаанд

хамрагдсан хүмүүсийн дөрвөн хүн тутмын нэг нь шүүх шударга үйлчилгээ үзүүлж байна гэж хариулсан бол 2014 онд бараг гурван хүн тутмын нэг нь шүүх шударга үйлчилгээ үзүүлж байна гэж хариулж байна.)


¹³ Дэлхийн банк, Авлигатай тэмцэх газрын Засаглалыг дэмжих төсөл. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх туршилт судалгааны үр дүн, тайлан. Улаанбаатар. 2009 он,

¹⁴ <http://www.santmaral.mn/sites/default/files/SPEAK%20IV%20mon.pdf>

6. “Азийн барометр” Олон улсын ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа (2003-2010 он)

Тайваны Үндэсний их сургууль, Улс төрийн боловсролын академи хамтран 2003, 2006, 2010 онд хэрэгжүүлсэн Азийн барометр олон улсын ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаанд Монгол Улсын шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг судалсан байдаг¹⁵.

График 6.1



Энэхүү судалгаа нь төрийн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг хэмжих үнэлгээ бүхий үндэсний хэмжээнд хийсэн социологийн судалгаа юм. Судалгаанаас иргэдийн шүүхийн байгууллагад итгэх итгэл 2010 оныг хүртэл буурах хандлагатай байгааг харж болно. Шүүхийн байгууллагад итгэдэг эерэг хариултын нийлбэр 2003 онд 46.4 хувь байсан бол 2010 онд 23.1 хувь болтол буурсан байна. /График 6.1/

Шүүхийн байгууллагад итгэдэггүй гэж хариулсан хариултын нийлбэр 2003 онд 52 хувийг эзэлж байсан бол 2010 онд 73.8 хувь болтол нэмэгдсэн байна. 2010 оны судалгаанаас үзвэл судалгаанд оролцсон дөрвөн хүн тутмын гурав нь шүүхийн байгууллагад итгэхгүй байгаа нь маш өндөр тоо юм.

Мөн 2005-2006 онд Улс төрийн боловсролын академиас “Олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа” явуулсан бөгөөд тус судалгаанд нийслэл болон орон нутагт 1200 хүнийг хамруулсан байна. Тус судалгаагаар 2005 онд шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд 26.6 хувь нь сайн, 37.1 хувь нь муу, 32.1 хувь нь муу, маш муу гэж хариулсан бол 4.6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Шүүх бие даасан, хараат бус байж чаддаг уу? гэсэн асуултанд 8 хувь нь тийм, 42.6 хувь нь алдаг оног, 33.5 хувь нь үгүй, 15.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Тус байгууллаас гүйцэтгэсэн судалгаагаар шүүхийн байгууллагын нэр хүнд төдийлөн сайн харагдахгүй байна¹⁶.

¹⁵ Улс төрийн боловсролын академи. Зүүн азийн барометр 2003, Азийн барометр 2006, Азийн барометр 2010 судалгаа.


¹⁶ Улс төрийн боловсролын академи. Олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа. 2006 он

7. Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын судалгаа (2008-2014 он)

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар нь улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааг жил бүр гүйцэтгэдэг байна¹⁷. Уг судалгаагаар шүүхийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, улс төрчдийн шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлж буй давтамжийг шинжээчдийн үнэлгээгээр гаргадаг байна.


2008-2012 он хүртэлх 5 жилийн судалгааны үр дүнг харьцуулбал шүүх эрх мэдлийн авлигад өртөх эрсдэл багасах хандлагатай байгааг харуулж байна. Сүүлийн буюу 2012 оны үнэлгээг өмнөх онтой харьцуулбал 0.73 пунктээр буурсан нь шүүх эрх мэдлийн салбар дахь авлигын түвшин аажмаар буурч байна. /График 7.1/

График 7.1



Түүнчлэн улс төрчдийн зүгээс шүүхэд нөлөөлж, ашигтай шийдвэр гаргуулах нөлөөллийн үнэлгээ бүхэлдээ нэмэгдсэнийг харуулж байна¹⁸. Улс төрчдийн шүүх эрх мэдэлд нөлөөлөх нөлөөлөл 2008–2010 онд тогтмол өсч, 2011 онд 0.21 пунктээр буурсан бол 2012 онд өмнөх оноос 0.27 пунктээр өсчээ. /График 7.2/

График 7.2



¹⁷ <http://www.iaac.mn/index.php?cid=208>

¹⁸ <http://www.iaac.mn/index.php?cid=208>

Авлигатай тэмцэх газрын 2012 оны судалгааны тайланд “Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахын тулд албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх, ур чадварт үндэслэн томилгоо хийх, байгууллагын ил тод байдлыг дээшлүүлэх, албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах, шударга ил тод механизм бий болгох, хуулийн байгууллагын чадавхийг сайжруулах зэрэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэсэн зөвлөмж гаргасан байна¹⁹.

2013 оноос эхлэн Авлигатай тэмцэх газрын хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны арга зүйд өөрчлөлт орсон байна. Тус байгууллагын 2013 оны судалгааны тайланд шүүх болон төрийн бусад байгууллага дахь авлигын төсөөллийн талаар нарийвчлан тусгаагүй байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн ерөнхий дүнгээр 2013 онд 3.68 гэсэн үнэлгээ, 2014 онд 3.58 гэсэн үнэлгээ гарсан нь эерэг үзүүлэлт бөгөөд энэ салбарын хүрээн дэх авлигын хэмжээ жил дараалан буурч байгааг харуулж байна. /График 7.3/

График 7.3



2014 оны судалгаагаар Монгол улсын улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг нарийвчлан тодорхойлсон бөгөөд шүүх байгууллага 3.28 гэсэн үнэлгээ авсан нь тус судалгаанд хамрагдсан байгууллагуудын дунджаас бага байна²⁰.

¹⁹ http://www.iaac.mn/pdf/ssha/Report_CPPLS_2012_new.pdf

²⁰ http://www.iaac.mn/pdf/ssha/Report_CPPLS_2014_new.pdf

8. Транспэрэнси интернэшнл байгууллагын авлигын индексийн судалгаа (Transparency International–Corruption Perception Index)

Транспэрэнси интернэшнл байгууллагын ‘Авлигын төсөөлөл’-ийн судалгаа нь 0-100 онооны шкалаар авлигын төсөөллийн үнэлгээг гаргадаг ба үнэлгээ “0” оноонд дөхөх тусам авлигын төвшин өндөр байгааг, “100” оноонд ойртох тусам авлигын түвшин бага байгааг илэрхийлдэг байна.

Монгол Улс 2012 онд 36 оноогоор 176 улсаас 94 дүгээр байр, 2013 онд 38 оноогоор 83 дугаар байр, 2014 онд 39 оноогоор 80 дугаар байранд жагсаж, авлигын үзүүлэлт жил дараалан буурсан байна²¹. Монгол улс авлигын үзүүлэлтээр сүүлийн гурван жилд 14 байраар урагшилсан байна. /График 8.1/

График 8.1



Тус байгууллагын дэлхий нийтийн авлигын хэмжүүр судалгаанд оролцогчдын 77 хувь нь төрийн албан хаагчид, 73 хувь нь шүүх, 71 хувь нь эрүүл мэндийн салбар, 66 хувь нь цагдаагийн байгууллага, 65 хувь нь улс төрийн намууд, 63 хувь нь УИХ, 63 хувь нь боловсролын систем авлигад өртсөн гэж хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлтүүд юм. Хамгийн их авлигатай 12 байгууллагыг жагсаавал шүүх 2 дугаарт орж байна.

Монгол улсад шүүхийн авлигыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь улсын хэмжээн дэх авлигыг бууруулахад гол нөлөө үзүүлнэ.

²¹ <http://www.transparency.org/cpi2014/results>

9. Эрх зүйт ёс ба авлигаас ангид байх үзүүлэлт (Heritage foundation) судалгаа

Эдийн засгийн эрх чөлөөний индекс гаргадаг дэлхийн нэр хүнд бүхий судалгааны байгууллага “Херитэйж фаундэйшн” (Heritage foundation), The Wall Street сэтгүүл–ийн хамтран гаргасан судалгаагаар 2015 онд Монгол Улс Эрх зүйт ёс (Rule of Law)–ны индикаторт авлигаас ангид байх үзүүлэлтээр 38.0 оноо авч, 178 орноос 83 дугаар байранд жагсчээ. /График 9.1/

График 9.1



Хэдийгээр дээрх судалгаа нь авлигын чиглэлээр дагнасан судалгаа биш боловч улс орны эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтийг тооцох 4 гол хүчин зүйлсийн нэг болох эрх зүйт ёс ба түүнийг илэрхийлэх үзүүлэлт нь авлигаас ангид байх ёстой юм. Тус судалгааны байгууллага “Монгол улсад авлига түгээмэл гэж үздэг. Улс төрийн авлига ихээхэн тархсан бөгөөд төрийн институтууд нь сул дорой учраас авлигын эсрэг үр дүнтэй тэмцэж чаддаггүй. Шүүх эрх мэдэл бие даасан боловч улс төрийн нөлөөнд өртөмтгий байна. Шүүгчдийн дунд авлига оршин тогтносоор байна²²” гэж дүгнэсэн байна.

Шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлж буй зүйл бол авлига бөгөөд сүүлийн жилүүдэд бага зэрэг буурч байгаа боловч шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд байсаар байна. Иймээс шүүхийн авлигын асуудлыг бууруулахад чиглэсэн ажлыг улам эрчимжүүлэх шаардлагатай байна.

²² <http://www.heritage.org/index/pdf/2015/countries/mongolia.pdf>

10. Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн судалгаа (2014 он)

Шүүхийн шинэтгэлийн үйл явцын талаар 2013 онд шүүгчдээс санал асуулга явуулж, шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлэхэд анхаарах зүйлсийг тодруулсан байна. Шүүхийн шинэчлэл таны хүлээж байсан асуудал мөн үү? гэсэн асуултанд 91.3 хувь нь тийм, 2.5 хувь нь үгүй, 6.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Шүүхийн шинэчлэлийн талаар хүлээлт маш өндөр байна.

Шүүхийн шинэтгэлд тохиолдож буй саад бэрхшээл юу вэ? гэсэн асуултанд 67.1 хувь нь эдийн засгийн баталгаа гэж хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Мөн 43.6 хувь нь Хууль эрх зүйн орчин хангалтгүй, 38.7 хувь нь шүүгчийн хараат байдал бол хамгийн их саад бэрхшээл болж байна гэж тус тус хариулжээ²³. /График 10.1/

График 9.1



11. Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаа

Шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэнгээс 2014 оны 10 дугаар сард явуулсан “Шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шинэтгэлийн явцын үнэлгээ” сэдэвт социологийн судалгаагаар шүүхээр үйлчлүүлсэн 999 хүнийг судалгаанд хамруулсан бөгөөд тус судалгаанд хамрагдсан иргэдийн 71 хувь нь шүүхэд итгэж байна гэж хариулсан бол 29 хувь нь шүүхэд буюу шүүхийн шийдвэрт итгэхгүй байна гэж хариулсан байна. Шүүхэд итгэхгүй байгаа шалтгааныг 37.8 хувь нь шүүх албан тушаалтанд үйлчилдэг, 37.5 хувь нь нотлох баримтыг бүрэн үнэлдэггүй, 37.5 хувь нь хараат бус ажилладаг эсэх нь эргэлзээтэй, 34.7 хувь нь авлига авдаг гэж хариулсан байна²⁴.

²³ Хууль зүйн Үндэсний хүрээлэн. Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2013 он. Цуврал-2, 107 дахь тал

²⁴ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. Шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шинэтгэлийн явцын үнэлгээ судалгааны тайлан. 2014 он.

Шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг 23 хувь нь “Сайн” авдаг, 59 хувь нь “Дунд”, 18 хувь нь мэдээлэл бага буюу “Тааруу” гэж хариулснаас үзвэл иргэдэд шүүхийн талаарх мэдлэг, мэдээлэл харьцангуй бага хүрдэг байна. Шүүхийн талаарх аливаа мэдээллийг телевизээс авдаг гэж 68.7 хувь нь хариулсан байна.

Шүүхээр үйлчлүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл гардаг талаар 62.5 хувь нь “цаг хугацаа алддаг”, 38.9 хувь нь “хүнд сурталтай”, 21.2 хувь нь шүүгч, шүүхийн захиргааны ажилтны харилцаа, хандлага сайн биш гэж хариулсан бол 29.8 хувь нь “өрөө тасалгаа муу, тайлбар өгөхөд хүндрэлтэй байдаг” гэж хариулсан байна. Шүүхийн ачаалал их, өрөө тасалгаа, байр зэрэг шүүхийн дэд бүтэц муу байгаагаас шүүхээр үйлчлүүлэхэд бэрхшээл гардаг байна²⁵. /График 11.1/

График 11.1



12. “Хөгжлийн эрэлд” судалгааны байгууллагын “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” социологийн судалгаа

Судалгаанд Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөрийн насны хүн амын төлөөлөл хамрагдсан. Судалгаа санамсаргүй түүврийн аргаар хийсэн ба экспертийн ярилцлагыг удирдах түвшний хүмүүсийн дунд зохион байгуулж, шүүхийн ажилтнууд, шүүхээр үйлчүүлж байсан болон шүүхээр үйлчүүлж байгаагүй нийт 3290 хүний мэдээлэлд тулгуурлаж шүүхийн шинэтгэл эрчимтэй эхэлсэнээс хойш буюу шүүхийн багц хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш 1,5 жилийн хугацаанд иргэд олон нийт шүүхэд итгэх итгэл 3 хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлох зорилгоор олон нийтийн санал бодлын судалгаа хийсэн байна.


Судалгааны гол үр дүн нь шүүхийн шинэтгэлийн хөтөлбөр батлагдсанаас хойш шүүхийн шинэтгэлийн үйл явц болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явц огтхон ч тасалдан саатаагүй бөгөөд энэ хоёр үйл явцын үр дүнг илэрхийлэх, үнэлэх бараг цорын ганц шалгуур үзүүлэлт бол шүүх засаглалд итгэх олон түмний итгэл юм.

Шүүхийн шинтгэлийн үйл явц эхлэхээс өмнө 2008 онд нээлттэй нийгэм форумаас АНУ-ын профессор Брент Уайлтаар хөндлөнгийн судалгаа хийлгэхэд шүүрэд итгэх итгэл 23.0 хувь, 2010 онд Сант марал судалгааны төвийн хийсэн судалгаагаар энэ үзүүлэлт 15.0 хувьтай болж буурч байсан байна.

Энэ судалгаагаар шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн **60.6 хувь нь өнөөдөр шүүх хэрэг маргааныг хуульд нийцүүлэн шудрагаар шийдвэрлэж байна гэдэгт итгэдэг** гэж хариулсан ба энэ үзүүлэлт шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд бүүр өндөр 81.4 хувь нь шүүхийн үйл ажиллагаа шудрага болно гэдэгт итгэж байна. Харин шүүхээр үйлчлүүлээгүй иргэд шүүх хэрэг маргааныг шудрага ар шийдвэрлэдэг гэдэгт итгэдэггүй /39.8/,

тэрчлэн хариулж мэдэхгүй байгаа 21.5 хувийн хамарч байгаа хүмүүсийн эзлэх хувь шүүхээр үйлчлүүлсэн иргэдийнхээс өндөр байна. /График 12.1/

График 12.1



13. “Монгол Улсын Шүүхийн байгууллагад хийсэн судалгаа /Judicial Integrity Scan/ ГОУХАН /GIZ/-аас хийсэн тайлан”

Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагын шинэтгэл, шүүхийн шударга байдалд Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллагын олон улсын мэргэжилтнүүд Judicial Integrity Scan буюу шүүхийн цогц зураглалын судалгаа хийлээ. Энэхүү судалгааны аргачлалыг НҮБ-аас гаргасан Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудад тулгуурлан тус байгууллагын мэргэшсэн экспертүүд боловсруулсан бөгөөд шүүх эрх мэдлийн байгууллага нь олон улсын стандарт шаардлагыг хангаж буй эсэхийг цогцоор нь үнэлдгээрээ онцлогтой.

Үнэлгээг олон улсын мэргэжилтнүүд баримт бичиг, хууль тогтоомжийн судалгаа (Desk study), шүүхийн болон бусад байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөлтэй хийх ярилцлагын судалгаа (Interview), дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах гэсэн үндсэн гурван шаттай ажилласан байна.

Судалгааны баг хараат бус, хөндлөнгийн байх зарчмыг баримтлан дараах шалгуурын дагуу үнэлгээгээ хийсэн:

- Шүүхийн хараат бус байдал (Independence);
- Төвийг сахисан шүүх эрх мэдэл (Impartiality);
- Шүүгчийн ёс зүй (Integrity);
- Шүүгчийн зохистой байдал (Propriety);
- Тэгш эрхийг эрхэмлэх (Equality);
- Хичээл зүтгэл, чадвар (Competence and Diligence).

Хөндлөнгийн судалгааны багийнхан Хууль зүйн яам, бүх шатны шүүхийн шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хуульчдын холбоо, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт, ярилцлага хийж, асуулга авснаас гадна шүүхүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж бодит байдалтай танилцаж дараах дүгнэлтийг хийжээ.

Судалгааны тайлангаас үзвэл Монгол Улсад 2002 оноос эхэлсэн шүүхийн шинэтгэлийн үйл явц 2013 оноос эрчимжсэн бөгөөд шинэтгэл нь нийгэм, эдийн засгийн хувьд ижил төстэй гарааны нөхцөлтэй байсан бусад орнуудтай харьцуулахад ихээхэн түрүүлж байгааг онцолжээ.

Мөн тайланд шүүхийн бие даасан байдлын талаар тогтоосон олон улсын стандартуудын дийлэнх хэсгийг хуулийн хэмжээнд тусгасан байх бөгөөд шүүхийн практикт хэрэгжиж байна гэж дүгнэжээ.

Тухайлбал, шүүхийн нээлттэй, ил тод байдал, хүртээмжийг бүрэн хангасан, шүүгчдийн цалин хөлсийг нэмэгдүүлж эдийн засгийн хувьд хараат бус ажиллах нөхцлийг бүрдүүлсэн, шүүгчдийн хувийн хараат бус байдлыг хангах замаар төрийн зүгээс нөлөөлөх боломжийг хязгаарласан, шүүгчдийн ажиллах нөхцлийг боломжийн түвшинд хангасан, шүүгчийн сахилга, ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэхэд улс төрийн нөлөөлөлгүй, шүүхийн төсөв, эдийн засгийн хэмжээ өсч байгаа нь судалгааны эерэг дүн гэж тодорхойлжээ.

14. “Транспэрэнси интернэшнл” олон улсын байгууллагаас хийсэн 2017 оны авлигын төсөөллийн индексийг танилцуулсан байдал

Монгол Улсын авлигын төсөөллийн индекс 2017 онд 36 оноотой болж, өмнөх оны үзүүлэлтээс 13 байраар ухарчээ. “Трансперенси интернэшнл” олон улсын байгууллагаас авлигын асуудлаарх нэр хүнд бүхий судалгаа, үнэлгээний 13 байгууллагын тайлан болон энэ чиглэлийн шинжээч, бизнесийн удирдах албан тушаалтнуудын үнэлгээнд тулгуурлан дээрх үнэлгээг гаргажээ.

Манай улсын авлигын төсөөллийн индексийн үнэлгээ юунаас болж буурсан шалтгааныг задлан шинжилж үзвэл, авлигын нөхцөлийг нэмэгдүүлдэг хүнд суртал, төрийн албанд томилоход мерит зарчмын хэрэгжилтийн байдал, төрийн эрхийг тодорхой эрх ашгийн төлөө авах зэрэг хүчин зүйлсийн улмаас буурсан байна. Тухайлбал, авлигын төсөөллийн индексийн нэг эх сурвалж болох “World Bank Country Policy and Institutional Assessment”-ийн тайланд Монгол Улс 2015, 2016 онд 100 онооноос 47 оноо авч байсан бол 2017 онд 43 оноо авч буурсан байна. Энэхүү үнэлгээг дараах 3 асуултаар хэмждэг байна. Үүнд:

Гүйцэтгэх засаглалын хариуцлагатай байдал. Төрийн албан хаагчид гаргасан шийдвэртээ болон гүйцэтгэлдээ хариуцлага хүлээдэг эсэх;

- Төрийн бус байгууллага ба иргэний нийгэм төрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг хугацаанд нь авах боломжтой байдаг эсэх;
- Төрийн үйл хэрэг хэсэг бүлэг хүмүүсийн далд ашиг сонирхолд автдаг эсэх.

Энэ нь шийдвэр гаргагч нарт хариуцлагын тогтолцоог сайжруулах болон бизнесийн орчин дахь авлигын эрсдэлийг бууруулах шаардлагатайг харуулж байна. Харин шүүх эрх мэдлийн үнэлгээ өссөн байна. Тодруулбал, авлигын төсөөллийн индексийн 13 эх сурвалжийн нэг болох “Bertelsmann Foundation Transformation Index”-ийн тайланд Монгол Улс 2015, 2016 онд 100 онооноос 36 оноо авч байсан бол 2017 онд 41 оноо авч дээшилсэн байна.

Мөн авлигын төсөөллийн индексийн өөр нэг эх сурвалж болох “Дэлхийн шударга ёсны төсөл”-ийн “Эрх зүйт ёсны индекс”-ийн 2017-2018 тайланд дурдсанаар, түүний нэг үзүүлэлт болох “шүүх авлигад өртөхгүй байдал”-ын үзүүлэлтээр Монгол Улс 2016 онд 0.48 оноотой байсан бол, 2017-2018 онд 0.52 болж эерэг үнэлгээ авсан байна. Дээрхээс харахад авлигатай тэмцэх үйл ажиллагаа дахь шүүх эрх мэдлийн ололт, амжилтыг бэхжүүлэх, энэ хүрээнд Засгийн газраас өөрийн бүрэн эрхийн хүрээнд шүүх эрх мэдлийг үргэлжлүүлэн хүндэтгэх, дэмжих хэрэгтэйг харуулж байна.

15. “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга байдлын судалгаа-шүүхийн байгууллагын тайлан” ШЕЗ, УЕПГ, ХЗДХЯ, МХХ хамтран баталсан удирдамжийн дагуу Азийн сангаас явуулсан судалгааны тайлан (2018.10 сар)

Судалгааг Улаанбаатар хот, бүсийн төлөөлөл болох 6 аймгийн хэмжээнд шүүх болон хуулийн байгууллагаас 2017-2018 онд үйлчилгээ авсан 814 иргэн (УБ-428, Орон нутаг- 386), 288 аж ахуйн нэгж байгууллага (ААНБ), мөн Шүүгч, прокурор, цагдаа, шүүхийн шинжээч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч, нотариатч, эвлэрүүлэн зуучлагч, нийт 938 хуульч, албан хаагчид оролцуулж Батлагдсан аргачлал, асуумжийн дагуу мэдээлэл цуглуулах, нэгтгэх ажлыг статистик судалгааны СИКА¹ компани 2018 оны 6 сарын 27-ноос 9 сарын 1-ний хооронд гүйцэтгэсэн байна.

Зорилго

Шүүх, хуулийн салбар ёс зүй, шударга байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь нийгмийн бүхий л салбарт хууль ёс тэгш хэрэгжих, шударга ёс хангагдахын үндэс суурь болдог. Тиймээс энэ салбарын талаарх иргэд, олон нийтийн үзэл бодол, хандлага, бодит нөхцөл байдлыг тодорхойлж, өөрчлөн сайжруулах санал, зөвлөмж гаргах

Зорилт

1. Шүүхийн байгууллагын үйлчилгээний үнэлгээ
2. Шүүгчийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага, ёс зүй
3. Шүүгчийн шударга байдал (Төсөөлөл)
4. Шүүгчид ирэх хөндлөнгийн нөлөөлөл (төсөөлөл)
5. Шүүгчид бусад албан хаагчдаас ирэх нөлөөлөл (тохиолдол)
6. Шүүгчээс иргэнд ирж буй зүй бус нөлөөлөл

Шүүхийн байгууллагын үйлчилгээний үнэлгээ

Шүүхийн байгууллагын өргөдөл, гомдол хүлээн авах үйлчилгээг судалгаанд оролцогчдын 64 хувь нь сайн, 20 хувь нь дунд, 11 хувь нь муу гэж үнэлжээ. Шүүхийн байгууллагын өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх үйлчилгээг судалгаанд оролцогчдын 50,5 хувь нь сайн, 25,3 хувь нь дунд, 18,3 хувь нь муу гэж үнэлжээ. Шүүхийн байгууллагын мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйлчилгээг судалгаанд оролцогчдын 41 хувь нь сайн, 20 хувь нь дунд, 32 хувь нь муу гэж үнэлжээ. Шүүхийн үйлчилгээ үзүүлэх байр түүний орчин нөхцөлд судалгаанд оролцогчдын 56,1 хувь нь сайн, 21,5 хувь нь дунд, 13,4 хувь нь муу гэж үнэлжээ.

Шүүхийн байгууллагын үйлчилгээний үнэлгээг нэгтгэн авч үзвэл судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь шүүхийн байгууллагын үйлчилгээний өргөдөл, гомдол хүлээн авах, түүнд хариу өгөх, тамгын газрын байр, орчин нөхцөл байдлыг сайн, боломжийн гэж үзэж байна. Хэдийгээр боломжийн хэмжээнд гэж оролцогчдын тал нь хариулсан ч цаашид харьцангуй тогтвортой шинжтэй энэ үзүүлэлтийг ахиулахын тулд Монгол Улс шүүхийн зориулалтын байр танхимыг барьж байгуулах, өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх процессыг иргэдэд ойр, түргэн шуурхай болгох, техник технологийн ололтыг ашиглаж цахимжуулах шаардлага байгааг дурдах нь зүйтэй.

Мөн анхаарал татахуйц нэг хэсэг байгаа нь шүүхээр үйлчлүүлж байгаа иргэд, олон нийтэд


¹ СИКА ХХК нь социологийн судалгаагаар мэргэшсэн 2008 онд байгуулагдсан компани. Эдийн засаг, нийгмийн салбарт олон судалгааг амжилттай гүйцэтгэсэн, социологийн судалгааны салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж буй туршлагатай цөөн байгууллагын нэг юм.

мэдээлэл өгөх, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг харьцангуй шүүмжилсэн буюу доогуур үнэлжээ. Зөвлөх, үйлчлэх зэрэг нь үйлчилгээний бодлого, баримталж буй хэм хэмжээ, сургалт дадлага зэрэг ажлын үр дүнд шийдэгдэж болох асуудал тул энэ чиглэлийн ажлыг холбогдох эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх, үйлчлүүлэгч, шүүхийн байгууллага хоорондын эргэх холбоог сайжруулах, шүүгч, ажилтнуудын харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлыг хийж гүйцэтгэх нь зүйтэй.

Шүүгчийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага, ёс зүй


Шүүгчийн харилцаа, хандлага, ёс зүй болон мэдлэг, ур чадварын талаар иргэн, аж ахуйн нэгж, бусад хуульчид, шүүгчид өөрсдөө үнэлсэн бөгөөд үнэлгээг тус бүрд нь авч үзье.

График 15.1



Шүүгчийн харилцаа, хандлага, ёс зүйн талаар судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ын 57,2 хувь нь сайн, 25 хувь нь дунд, 10,3 хувь нь муу гэсэн үнэлгээ өгсөн бол шүүгчдийн 78 хувь нь сайн, 16,8 хувь нь дунд, 1,3 хувь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

График 15.2



Шүүгчийн мэдлэг, ур чадварын талаар судалгаанд хамрагдсан шүүгчдийн 75,5 хувь нь сайн, 19,4 хувь нь дунд, 1,2 хувь нь муу гэсэн үнэлгээг өгсөн бол бусад салбарын (шүүгчээс гадна) 783 албан хаагчдын 57,5 хувь нь сайн, 30,3 хувь нь дунд, 5,3 хувь нь муу гэж үнэлжээ.

Шүүгчийн харилцаа, хандлагын асуудлыг авч үзвэл иргэн, ААНБ-ын төлөөллийн талаах дийлэнх нь сайн, маш сайн гэсэн эерэг үнэлгээ өгсөн бол шүүгчид өөрсдийн харилцаа хандлагыг 78 хувь сайн гэж үнэлсэн байна. Дунд болон муу үнэлгээний хувьд ААНБ-аас илүү хувь иргэд өгчээ. Эндээс үзвэл ер нь эрх зүйн мэдлэг хомс иргэд рүү хандсан харилцаа хандлагыг дээшлүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Мэдлэг чадварын хувьд шүүгчдийн 75 хувь нь сайн, бусад албан хаагчдын 57 хувь нь сайн гэсэн үнэлгээг өгсөн байна. Дунд үнэлгээний хувьд шүүгчдийн 19, бусад албан хаагчдын 30 гаруй хувь нь өгчээ.


Нэгтгэн авч үзвэл судалгаанд оролцогчдын олонх нь шүүгчдийн харилцаа хандлага,

мэдлэг чадварыг дундаас дээш үнэлж байгаа ч шүүгчид өөрсдийгөө үнэлж буй дүн, иргэд аж ахуй нэгж, бусад алба хаагчдын үнэлгээ хоёрт ялгаатай байдал харагдаж байна. Шүүхийн үйл ажиллагаа, шүүгчийн ёс зүй, харилцаа хандлагын нэг хэмжигдэхүүн нь олон нийтийн нүдэнд шүүх эрх мэдэл, шүүгчид чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаагаар тодорхойлогддог гэдгийг энд дурдах нь зүйтэй. Энэ өнцгөөс авч үзвэл хэргийн оролцогч талууд тэдгээрийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч нартай зүй зохистой харьцах, харьцаандаа цаашид анхаарах, үүнийг дагаад шүүгч нарын мэдлэг ур чадварын асуудал салшгүй холбоотой байгаа учир энэ тал дээр анхаарах, мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог сайжруулах, шүүгчдийн сонгон шалгаруулалтад анхнаасаа зан төлөвийн хувьд төлөвшсөн, эелдэг, харилцааны ур чадвар эзэмшсэн нэр дэвшигчийг тодруулах, шүүгчийн сургалтын тогтолцоог өргөжүүлэх, эрчимжүүлэх шаардлага байна.

Шүүгчийн шударга байдал (Төсөөлөл)

Судалгаанд оролцогчдоос “Шүүгч хэрэг маргааныг хэр шударга шийддэг вэ?” гэж асууж, 10-100 хүртэлх хувиар үнэлгээ өгсөн байдлыг авч үзэхэд иргэдийн 16 хувь, ААНБ-ын 13,9 хувь, хуульчдаас бусад хүмүүсийн 11,4 хувь нь 100 хувь хэрэг маргааныг шударга шийдвэрлэдэг гэж хариулжээ.

График 15.3



Мөн оролцогчдын өгсөн үнэлгээнээс 50-90 хүртэлх хувиар үнэлгээ өгсөн байдлыг нь авч үзэхэд иргэдийн 47,3 хувь, ААНБ-ын 61.4 хувь, хуульчдаас бусад хүмүүсийн 63.3 хувь нь шүүгчийн шударга байдалд 50 хувиас дээш итгэдэг гэж хариулсан байна.

Харин оролцогчдын 10-50 хүртэлх хувиар үнэлгээ өгсөн байдлыг авч үзэхэд иргэдийн 31,7 хувь, ААНБ-ын 34,2 хувь, хуульчдаас бусад хүмүүсийн 25,3 хувь нь 50 хувиас доош үнэлгээ өгсөн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 25-34 орчин хувь нь шүүгч хэрэг маргааныг шударга шийднэ гэдэгт эргэлздэг, итгэдэггүй гэсэн үзүүлэлт харагдаж байна.

Түүнчлэн судалгаанд оролцсон шүүгчдээс “Шүүгч хэрэг маргааныг хэр шударга шийддэг гэж та бодож байна?” гэж асууж, 10-100 хүртэлх хувиар үнэлгээ өгүүлэхэд 32.9 хувь нь 100 хувь, 34.2 хувь нь 90 хувь, 18.7 хувь нь 80 хувь, 7.1 хувь нь 70 хувь, 2.6 хувь нь 60 хүртэлх хувиар үнэлсэн бол 4.4 хувь нь 50-аас доош хүртэл хувиар үнэлсэн байна.

Судалгаагаар “Хуульч, албан хаагч нийт хэрэг, маргааны хэдэн хувийг шударгаар буюу хууль ёсны дагуу шийддэг гэж та үзэж байна?” гэсэн асуултын дагуу хуульч, албан хаагч тус бүрийн шударга байдлыг иргэн, аж ахуйн нэгж болон хуульчдаар үнэлүүлсэн. Иргэний асуултад мэдэхгүй хариулт орсон. Харин хуульчийн асуулгад хэрэв мэдэхгүй бол бөглөхгүй байхаар зааварчилгаа өгч мэдээллийг авсан. Шүүгчийн шударга байдлын талаарх санал бодол иргэд, ААНБ-ын хувьд нэлээд хуваагдмал байна. Мөн шүүгч хэрэг маргааныг 100 хувь шударгаар

шийддэг гэх шүүгчдийн хувь хэмжээ ердөө 30 хувьтай байна. Мөн бусад салбарын 783 албан хаагчийн 11 хувь нь Шүүгч асуудал хэрэг маргааныг 100 хувь, 21 хувь нь 80 хувийг шударгаар буюу хууль ёсны дагуу шийддэг гэж үзжээ.


Шударга байдлыг нэгтгээд дүгнэвэл шүүгчид өөрсдийн шударга байдалд ихэнх нь буюу 80 хүртэлх хувь нь шударга гэж 95 хувь нь үзэж байгаа бол иргэд, ААНБ-ын хувьд арай өөр бодолтой байна. Тэд шүүгч нарын дийлэнх нь буюу 80 хүртэлх хувь нь шударга гэж 1/3 нь үзэж байна. Лавшруулбал иргэд, ААНБ-ууд 2 шүүгч тутмын 1 нь шударга гэдэгт эргэлзээтэй байна. Энэ байдал бусад хуульчдын үнэлгээнд мөн адил дурдагджээ. Тухайлбал, прокурор, өмгөөлөгч, шийдвэр гүйцэтгэгчид шүүгчдийн шударга байдалд мөн адил хандсан байна.

Ер нь шүүгч хүний хэрэгжүүлдэг ажил үүргийн онцлог нь олны хараа хяналт, байнгын шүүмжид байдаг явдал. Ёс зүй, зан харилцааны жижиг алдаа нь шүүгчийн шударга байдалд эргэлзэх эргэлзээг төрүүлдэг. Иймд энэ асуулгын судалгааны мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ шүүгчийн хараат бус байдал, хариуцлага, ёс зүйн харилцаа, хандлага, сонгон шалгаруулалт зэрэг цогцоор нь хандвал зүйтэй. Юуны өмнө хараат бус байдлын баталгааг нь сайжруулах, ялангуяа хууль зүй, эдийн засаг, үйл ажиллагааны баталгааг нь хангах, сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох, харилцааны чиглэлээр хандлагын өөрчлөлтийг бий болгох сургалт зохион байгуулах, ёс зүйн хэм хэмжээг нь боловсронгуй болгох, хэрэгжих механизмыг нь сайжруулах, гарцаагүй хэрэгждэг болгох зэрэг олон асуудлыг авч үзэх ёстой.

Шүүгчид ирэх хөндлөнгийн нөлөөлөл (төсөөлөл)

Асуудал, хэрэг маргааныг шийдвэрлэх явцад ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зүгээс хуульч, албан хаагчдад ирж буй хууль бус нөлөөллийн түвшин ямар байна вэ? асуултад шүүгчид хөндлөнгийн нөлөөлөл ирдэг гэж үзсэн нийт 407 иргэн, 162 аж ахуйн нэгжийн төлөөлөл хариулсан байна. Аж ахуйн нэгжийн нөлөөллийн үнэлгээг Хавсралт 1-ээс харна уу.

График 15.4



Шүүгчид ирж буй хөндлөнгийн бодит нөлөөллийг доорх судалгааны тоон үзүүлэлтээр хэмжсэн. Судалгаанд оролцсон 155 шүүгчийн 69.6 хувь буюу 108 шүүгч өнгөрсөн нэг жилийн хугацаанд өөрт нь ямар нэг хэлбэрийн зүй бус, хууль бус нөлөөлөл ирсэн гэж хариулсан байна.

Шүүгчид зүй бус, хууль бус нөлөөлсөн байдлыг авч үзэхэд иргэний зүгээс зүй бус үйлдэл гаргасан тохиолдол нийслэлд 61.9 хувь, орон нутагт 60 хувь, ААНБ, түүний төлөөллийн зүгээс зүй бус үйлдэл гарсан тохиолдол нийслэлд 31.4 хувь, орон нутагт 28 хувь, захиргааны байгууллага, түүний төлөөллийн зүгээс зүй бус үйлдэл гаргасан тохиолдол нийслэлд 15.2 хувь, орон нутагт 36 хувьтай байна.

Энэ судалгааны үзүүлэлтээс үзэхэд шүүгчид иргэний зүгээс зүй бус үйлдэл гарган нөлөөлсөн

тохиолдол нийслэл төдийгүй орон нутагт өндөр буюу 60 орчим хувийг эзэлж байгаа бол захиргааны байгууллага, түүний төлөөллийн зүгээс зүй бус үйлдэл гаргасан тохиолдол орон нутагт өндөр байна.

Харин дээрх шүүгчид зүй бус, хууль бус нөлөөлсөн үйлдлийг төрлөөр авч үзвэл хэргийн холбогдогч иргэнээс боловсон бус, зохисгүй харьцсан үйлдэл нийслэлд 92.3 хувь, орон нутагт 83.3 хувь буюу хамгийн өндөр байна.

Судалгаа шүүгчид ирж буй хөндлөнгийн бодит нөлөөллийг тоон үзүүлэлтээр хэмжсэн.

Тодруулбал нийт 155 шүүгчээс 108 нь өнгөрсөн 1 жилийн хугацаанд өөрт нь ямар нэг хэлбэрийн зүй бус, хууль бус нөлөөлөл ирсэн гэж хариулсан. Үүнээс дунджаар 61 хувь нь хэргийн холбогдогч иргэнээс ирсэн хууль бус нөлөөлөл байна.

График 15.5





График 15.6



Шүүгчид бусад албан хаагчдаас ирэх нөлөөлөл (тохиолдол)

Судалгаанд хамрагдсан нийт шүүгчийн 57.4 хувь буюу 89 шүүгчид өнгөрсөн 1 жилийн

хугацаанд өөрт нь бусад албан хаагчдаас ямар нэг зүй бус, хууль бус нөлөөлөл ирсэн гэж хариулжээ.

Давхардсан тоогоор 145 нөлөөллийн тохиолдол байгаагаас өмгөөлөгчийн зүгээс зүй бус нөлөөлөл ирсэн тохиолдол хамгийн өндөр буюу нийслэлд 50, орон нутагт 25 байна. Харин шүүгчид бусад шүүгчийн зүгээс зүй бус нөлөөлөл ирсэн нийслэлд 9, орон нутаг 7 тохиолдол гарсан нь анхаарал татаж байна.

Нөлөөллийн тохиолдлоос зүй бус үйлдлийн төрлийг авч үзэхэд харилцаа, хандлага, ёс зүйн асуудал дийлэнх тохиолдлыг эзэлж байна. Харин шүүгчээс шүүгчид нөлөөлөл буюу “хэрэг, маргааныг тодорхой байдлаар шийдэхийг гуйсан, ятгасан, тайлбарлаж ойлгуулахыг оролдсон” зүй бус үйлдэл нийслэлд 60 удаа бүртгэгдсэн байна. Түүнчлэн шууд тушаасан, үүрэг даалгавар өгсөн 6 тохиолдол, хамт ажиллагсад, удирдах албан тушаалтнаар дамжуулан нөлөөлөхийг оролдсон 7 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь анхаарал татаж байна.

Мөн бусад хуульч, албан хаагчаас ирсэн хууль бус нөлөөллийн дунджаар 13.5 хувь нь дээд түвшний авлигын шинжтэй байсан гэж үзжээ.

Судалгаанд хамрагдсан нийт шүүгчийн 57.4 хувь буюу 89 шүүгчид өнгөрсөн 1 жилийн хугацаанд өөрт нь бусад албан хаагчдаас ямар нэг зүй бус, хууль бус нөлөөлөл ирсэн гэж хариулжээ. Давхардсан тоогоор 145 нөлөөллийн тохиолдол байгаагаас өмгөөлөгчийн зүгээс зүй бус нөлөөлөл ирсэн гэсэн хариулт өндөр байна. Зүй бус үйлдлийн дийлэнхийг харилцаа, хандлага, ёс зүйн асуудал эзэлж байна. Мөн бусад хуульч, албан хаагчаас ирсэн хууль бус нөлөөллийн дунджаар 13.5 хувь нь дээд түвшний авлигын шинжтэй байсан гэж үзжээ.

График 15.7




Бусад хуульч, албан хаагчаас зүй бус үйлдэл ирсэн гэх нийт хариултын 16 нь уг зүй бус үйлдэл шүүгчээс шүүгчид ирсэн байна. Гэхдээ шүүгчээс шүүгчид “хэрэг, маргааныг тодорхой байдлаар шийдэхийг гуйсан, ятгасан, тайлбарлаж ойлгуулахыг оролдсон” зүй бус үйлдэл нэлээд олон буюу 60 удаа бүртгэгджээ.

График 15.8

Шүүгчээс шүүгчид ирсэн зүйл бус үйлдэл



График 15.9



Нэгтгээд авч үзвэл, шүүгчдийн тавны нэг нь ямар нэг байдлаар гадны болон дотоодын нөлөөлөл байдаг гэж үзэж байгаа бол иргэд олон нийтийн тавны дөрөв нь шүүгч нарт тодорхой нөлөө байдаг гэсэн төсөөлөлтэй байна. Харин тохиолдлын хувьд иргэд олон нийт, ААНБ болон захиргааны байгууллагаас ирэх нөлөөлөл байдаг байна. Энэ нь нийслэлд иргэд олон нийт болон ААНБ-аас ирэх нөлөөлөл илүү байдаг бол орон нутагт захиргааны байгууллагаас ирэх нөлөөлөл илүү байдаг гэжээ. Нөлөөллийн төрөл хэлбэрийн хувьд голлон буюу 90 орчим хувь нь харьцаа, хандлагын асуудал байдаг байна. Энэ байдалд арга хэмжээ авахдаа дийлэнх нь шаардлага тавьдаг бол 1/3 байдалд нь нөлөөллийн мэдүүлэг бөглөдөг гэжээ. Гэтэл нөлөөллийн мэдүүлгийн хэрэгжилт, түүнийг хэрэгжүүлэх механизм бүрэн гүйцэд бүрдээгүй байна.

Мөн судалгаанд хамрагдсан шүүгчдийн 60 орчим хувь буюу 89 шүүгчид өнгөрсөн 1 жилийн хугацаанд давхардсан тоогоор 145 удаа нөлөөллийн тохиолдол байна гэж хариулсан байна. Түүний дийлэнх нь өмгөөлөгчөөс байдаг байна. Харин шүүгч шүүгчтэй нөлөөлсөн, нөлөөлөх гэж оролдсон байдал нийслэлд 9, орон нутагт 7 тохиолдол гарсан гэжээ.

Иймээс шүүхийн хараат бус байдлын баталгааг хангах, энэ талыг үйл ажиллагааг улам идэвхжүүлэх, иргэд олон нийт, бусад хэргийн оролцогч нарын харилцаа, хандлагыг өөрчлөх, соён гэгээрүүлэх зэргээр нөлөөллийн ажиллагаа хийх шаардлагатай. Мөн одоогийн байгаа

нөлөөллийн мэдүүлэг бөглөдөг байдлыг идэвхжүүлэх, шүүгч нарыг сэдэлжүүлэх, нөлөөллийн мэдүүлэг бөглөх нууцлалын баталгаа, аль аль талдаа хараат бус байдлыг хангах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Шүүгчээс иргэнд ирж буй зүй бус нөлөөлөл


Судалгаанд хамрагдсан иргэдийн орон нутаг 6 хувь, нийслэлд 19,4 хувь нь шүүгчийн зүгээс ямар нэг зүй бус үйлдэл гаргадаг гэж хариулжээ.

Дээрх хариултаас шүүгчийн зүгээс иргэнд ирсэн зүй бус үйлдлийг төрлөөр ангилбал 66 тохиолдол буюу 27,7 хувь нь “Шүүгч үл тоомсорлосон”, 43 тохиолдол буюу 18 хувь нь “чиг үүргээ гүйцэтгэхгүй байх, эсвэл удаашруулах замаар аргагүй байдалд оруулсан” гэж тус тус хариулжээ. Мөн 35 тохиолдол буюу 14,7 хувь нь “Шүүгч ялгаварлан гадуурхсан” гэж хариулсан байна.

Нийт 238 зүй бус үйлдлийн хариуд шаардлага тавих, гомдол гаргах зэрэг хариу үйлдэл үзүүлсэн 105 тохиолдол бүртгэгджээ. Үүнээс орон нутагт 23 тохиолдол гарсан байгаа нь 21,9 хувийг эзэлж байна. Хариу үйлдлийн төрлөөр нь авч үзвэл “огт хариу үйлдэл үзүүлээгүй” 54 тохиолдол буюу 51,4 хувь, “Дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандсан” тохиолдол 26 буюу 24,7 хувь, “Зохисгүй үйлдлээ зогсоохыг шаардсан” тохиолдол 24 буюу 13,3 хувийг тус тус эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн дунджаар 29.2 хувь буюу 238 нь шүүгчийн зүгээс ямар нэг зүй бус үйлдэл гарсан гэж хариулжээ. Зүй бус үйлдлүүдийг задлаж үзвэл 63.3 хувь нь “Шүүгч үл тоомсорлосон” гэж хариулсан бол, 40 хувь нь “чиг үүргээ гүйцэтгэхгүй байх, эсвэл удаашруулах замаар аргагүй байдалд оруулсан” гэж хариулжээ. Мөн 35 тохиолдол буюу 33 хувь нь “Шүүгч ялгаварлан гадуурхсан” гэж хариулсан байна. Нийт 238 зүй бус үйлдлийн хариуд шаардлага тавих, гомдол гаргах зэрэг хариу үйлдэл үзүүлсэн 105 тохиолдол бүртгэгджээ. Зүй бус үйлдэл үзүүлэх хариу үйлдэл орон нутагт бага байна.

График 15.10





Шүүгчийн зүгээс бусад албан хаагчдад ирсэн зүй бус үйлдлийг задлан харвал "Боловсон бус, зохисгүй харьцсан" хамгийн өндөр буюу 58.2 хувь, "Үл тоомсорлосон, үл хайхарсан" үйлдэл гаргасан гэж хариулсан 51.8 хувь байна. Тодруулбал, шүүгчээс зүй бус үйлдэл ирсэн нийт 302 удаагийн хариулт 170 оролцогчоос давхардсан тоогоор ирсэн байна. Мөн хамгийн багадаа 1 удаа, хамгийн ихдээ 50 удаа тохиолдсон гэжээ.

График 15.12



Шүүгчийн зүгээс ирсэн боловсон бус, зохисгүй харьцах, доромжлох гэх мэт зүй бус үйлдлийн 31.8 хувь нь дээд түвшний авлигын шинжтэй байсан хэмээн судалгаанд хамрагдсан бусад хуульчид хариулжээ.

Иргэнд шүүгчийн зүгээс нөлөөлөх, зохисгүй үйлдэл гаргах байдал 10 гаруй хувьтай байна. Энэ 10 шүүгч тутмын 1 нь иргэнд ямар нэг байдлаар эвгүй харьцдаг, зохисгүй харагддаг гэсэн үг

юм. Түүний ихэнх тохиолдол нь харилцаа хандлагын асуудал болон эс үйлдэхүй буюу чиг үүргээ гүйцэтгэхгүй байх гэж иргэд үзжээ. Мөн шүүгч нарын зүй бус үйлдэл дээд түвшний авлигатай холбоотой гэж 1/3 нь үзсэн байна.

Иймээс шүүгч нарын харилцаа, хандлагыг өөрчлөх, иргэд олон нийтэд нээлттэй, ил тод байдлыг хангах ажлыг нэмэгдүүлэх, үе шаттай арга хэмжээ авах, мөн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа нь дахин хөндөгдөж байна.

Дүгнэлт:

1. Шүүхийн байгууллага өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэж байгаа үйл ажиллагаа, үйлчилгээний байр, орчин нөхцөлийн талаар судалгаанд оролцогчдын 50 ба түүнээс дээш хувь нь сайн, маш сайн гэж үнэлсэн байна. Харин шүүхийн байгууллагын зүгээс иргэдэд мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйлчилгээний тал дээр учир дутагдалтай, сайжруулах зүйлүүд байгааг анхаарч цаашид шүүхийн үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн ажлуудыг илүү сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай байна.
2. Судалгааны нийт дүнгээс авч үзэхэд шүүгчийн харилцаа, хандлага, ёс зүй, мэдлэг, ур чадварын талаар судалгаанд оролцогчдын өгсөн үнэлгээ нь 50 ба түүнээс дээш үнэлгээтэй байгаа хэдийч “дунд”, “муу” гэсэн үнэлгээг анхаарч ажиллах шаардлагатай байна. Хэдийгээр энэ судалгааны үзүүлэлт нь судалгаанд оролцогчдын субъектив үнэлэлтээс хамаарсан үнэлгээ боловч шүүгч нь Монгол Улсын хууль тогтоомж, Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасны дагуу ёс зүйн өндөр хэм хэмжээг сахиж ажиллах, мэдлэг, ур чадвараа дээшүүлэх тогтолцоог хөгжүүлэх, өөрийн үйлдэл, харилцаанд анхаарах ёстой.
3. Шүүгчийн шударга байдлын талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээнээс харахад ерөнхийдөө 50 хувиас дээш үзүүлэлт нь 60 ба түүнээс дээш хувьтай, 50 хувиас доош үзүүлэлт нь 34 орчим хувийг эзэлж байгаа тул цаашид иргэдийн итгэлийг тасралтгүй нэмэгдүүлэх, үзүүлэлтийг бууруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.
4. Шүүгчид хэргийн холбогдогч иргэн, өмгөөлөгч, прокуророос ирэх зохисгүй, зүй бус байдал, шууд ба шууд бус хэлбэрийн хөндлөнгийн нөлөөлөл их байна. Ялангуяа шүүгчид бусад шүүгчийн зүгээс нөлөөлсөн 16 тохиолдол, шууд тушаасан, үүрэг даалгавар өгсөн 6 тохиолдол, хамт ажиллагсад, удирдах албан тушаалтнаар дамжуулан нөлөөлөхийг оролдсон 7 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь анхаарал хандуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хориглосон шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцсон тохиолдол гарч байгаа нь шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, нөлөөлсөн этгээдэд хариуцлага тооцох, хариуцлагын механизмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна

16. “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгааны тайлан (2017-2019 он)

Судалгааны хүрээ

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шүүхийн багц хуулийг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн үйлчилгээг ил тод нээлттэй, хүртээмжтэй болгох, олон нийтийн хяналтыг тогтоох нөхцөлийг бүрдүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх байдалд онцгой анхаарч ирсэн билээ. Энэ хүрээнд 2014 онд Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүх ба олон нийт” хөтөлбөрийг баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн 2017 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” сэдэвт олон нийтийн санал асуулга явуулах тухай тушаал баталсан бөгөөд уг судалгааг жилд 2-оос доошгүй удаа авах, ингэхдээ нөхцөл байдлыг бодитой үнэлэх үүднээс шүүхээр үйлчлүүлсэн иргэд болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн хүрээнд явуулдаг болно.

Зорилго

Шүүх ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх, эргэх холбоо тогтоох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгоход энэ судалгааны зорилго оршино.

Дээрх зорилгод үндэслэн олон нийтийн санаа бодлыг дараах байдлаар томъёолж, мэдээлэл цуглуулав. Үүнд:

- Шүүхийн үйлчилгээ, хүндрэл, бэрхшээл;
- Шүүх өөрчлөгдсөн эсэх, шүүхийн өөрчлөлт;
- Шүүхэд итгэх иргэдийн итгэл, шударга байдал;
- Шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн талаарх иргэдийн төсөөлөл;
- Шүүхийн шинэтгэлд цаашид тулгарч буй сорилт;

Зохион байгуулалт

Судалгааны мэдээллийг Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах бүх шатны шүүхийн хэмжээнд шүүхээр үйлчлүүлсэн болон үйлчлүүлээгүй 3000 гаруй иргэдээс социологийн судалгааны санал асуулгын аргыг ашиглан авдаг.

Жич: Энэхүү судалгааны асуумжийг 2019.11 сард шинэчлэн боловсруулсан. Цаашид илүү дэлгэрэнгүй, олон нийтийн хүсэж буй сэдвээр мэдээлэл цуглуулахаар болсон.

Үр дүн

Шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байна

Энэ санал асуулгын судалгаагаар иргэдийн 64.8 хувь шүүхэд итгэдэг гэсэн үзүүлэлт гарсан нь шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байгааг харуулж байна. Энэ нь өмнөх онд хийгдсэн судалгааны дүн (67.2%)-ээс 3 орчим хувиар буурсан үзүүлэлт юм. Харин шүүхийн шинэтгэл эхлэхээс өмнөх 2007 оны судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 30 орчим хувьтай байсан бол 2015 оны байдлаар иргэдийн итгэл 60-80 хувь болж өссөн гэсэн хөндлөнгийн байгууллагын судалгааны үр дүнг бататгасан хэвээр байна.

Судалгаагаар шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр хүнийг ялгаварладаггүй гэж иргэдийн 51.7 хувь нь үзжээ. Шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн олонх нь буюу 67.9 хувь нь өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийн шүүхийн шүүгчийн талаар эерэг бодолтой байна. Мөн иргэдийн 50 гаруй хувь нь шүүгчийн сонгон шалгаруулалтаар зөв хүнийг олж байна, итгэж байна гэж хариулсан байна.

Шүүхийн шинэтгэл иргэдэд хүрч байна

Иргэдийн 30-40 хувьд шүүх шинэчлэгдэн сайжирч байгааг мэдэрсэн гэсэн хариулт өгснөөс үзвэл шүүхийн шинэтгэл бодитой үр дүнд хүрснийг иргэдийн 1/3 хувь нь шууд хүлээн зөвшөөрч байна гэж үзэж болохоор байна.

Иргэд шинэтгэл ерөнхийдөө мэдрэгдэж байна, шүүхийн үйлчилгээ өмнөхөөсөө мэдэгдэхүйц сайжирч байна, эвлэрүүлэн зуучлал үр дүнтэй хэрэгжиж байгаа гэдэгтэй хамгийн их санал нийлжээ. Түүнчлэн шүүхийн үйлчилгээнд цахим инновац нэвтэрсэн, шүүхийн шийдвэр нээлттэй, үйл ажиллагаа нь ил тод болсон гэдэгтэй иргэдийн олонх санал нийлжээ.

Харин шүүх бие даасан захиргаатай болсон, шүүхийн хараат бус байдал дээшилсэн, шүүхийн хүний нөөц шинэчлэгдэж байгаа, шүүх дагнаж, шүүгч мэргэшсэн зэрэг шинэтгэлийн өөрчлөлтүүд иргэдэд харьцангуй бага мэдрэгдсэн байна. Иймд эдгээр чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг илтгэнэ.

Энэ удаад шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэхийн тулд цаашид юунд анхаарах талаар иргэд Шүүхэд хандах иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, Шүүгчид сайн хүнийг томилох, Шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, Мэдээллийн ил тод байдлыг хангах, Шүүгчийн нөлөөлдөг танил талын нөлөөг хаах гэж үзэж байна.

Шүүхээр үйлчлүүлсэн судалгаанд оролцогчид шүүгчийн мэдлэг, чадварт эргэлздэг гээд цаашид Шүүгч ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх (33.6%), 36.6 хувь нь Шүүгчид сайн хүнийг томилох, Мэдээллийн ил тод байдлыг хангах (25.7%) зэрэг санал гаргаж шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлага байгааг тус судалгаа харуулж байна.

Судалгааны үр дүнд тулгуурлаж дараах товч зөвлөмжийг гаргаж байна.

- Шүүгчийн хараат бус ажиллах баталгааг бий болгох, хариуцлагын тогтолцоог сайжруулах
- Шүүгчид нөлөөлдөг нөлөөллийг багасгах, “нөлөөллийн мэдүүлэг” бөглөдөг тогтолцоог улам боловсронгуй болгох, энэ талын үйл ажиллагааг идэвхжүүлж иргэд олон нийтэд сурталчлах
- Шүүгчийн тоог нэмэгдүүлэх, шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх;
- Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог сайжруулах, шүүхийн ажилтнуудыг урьдчилж бэлтгэдэг институттэй болох, шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх;
- Шүүхийн үйлчилгээг орчин үежүүлэх чиглэлээр төсөв хөрөнгийг шийдвэрлэх, шүүхийн мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг сайжруулах;
- Шүүхийн дэд бүтэц, нэн ялангуяа нийслэл дэх шүүхүүдийн дэд бүтцийг оновчтой бүрдүүлж, шүүхээр үйлчлүүлэгч иргэд шүүхийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлэх;
- Шүүхийн нэр хүнд, шүүгчид итгэх олон нийтийн итгэл буурах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг тогтмол өсгөх чиглэлд төлөвлөгөөт арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх;
- Шинэтгэлийн чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх.

ДҮГНЭЛТ

- ❖ Шүүх эрх мэдлийн байгууллагад итгэх олон нийтийн итгэл сүүлийн жилүүдэд харьцангуй сайжирч байна. Энэ нь дээрх чиглэлээр судалгаа явуулсан бүх байгууллагын судалгааны дүнгээр нотлогдож байна.

Энэ нь 2003-2010 онд явагдсан судалгаанаас үзвэл шүүхийн талаар олон нийтийн үнэлгээнд эерэг хариулт гараагүй, шүүхэд итгэх итгэл улам бүр алдарч байгааг ШУА-ын ФСЭХ-ийн судалгаанд дурьдсан. Мөн дөрвөн хүн тутмын гурав нь буюу 75 хувь нь шүүхэд итгэхгүй байгааг 2010 онд явагдсан “Сант марал сан”-ийн судалгаа болон УТБА-ын “Азийн барометр” судалгаагаар илэрхийлсэн.

Харин 2015 онд хийгдсэн “Хөгжлийн эрэлд” ХХК-ний хийсэн судалгаагаар иргэдийн шүүхэд итгэдэг байдал 65 хувь, 2017 онд хагас жилийн зайтай хоёр удаа хийгдсэн “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгааны дүнгээр иргэдийн шүүхэд итгэдэг байдал 63-65 хувийн үзүүлэлтэй байсан нь сүүлийн жилүүдэд шүүх эрх мэдэл, шүүхийн үйлчилгээ, шүүхэд байгууллагад итгэх иргэдийн итгэл харьцангуй сайжирсан байгааг нотлож байна.

Мөн 2018 онд хийгдсэн Азийн сангийн Шүүгчийн шударга байдлын талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээнээс харахад ерөнхийдөө 50 хувиас дээш үзүүлэлт нь 60 ба түүнээс дээш хувьтай, 50 хувиас доош үзүүлэлт нь 34 орчим хувийг эзэлж байгаа тул цаашид иргэдийн итгэлийг тасралтгүй нэмэгдүүлэх, үзүүлэлтийг бууруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.

- ❖ Шүүхийн байгууллага өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэж байгаа үйл ажиллагаа, үйлчилгээний байр, орчин нөхцөлийн талаар судалгаанд оролцогчдын 50 ба түүнээс дээш хувь нь сайн, маш сайн гэж Азийн сангаас хийсэн 2018 оны судалгаанд үнэлжээ. Харин шүүхийн байгууллагын зүгээс иргэдэд мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйлчилгээний тал дээр учир дутагдалтай, сайжруулах зүйлүүд байгааг анхаарч цаашид шүүхийн үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн ажлуудыг илүү сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай байна.
- ❖ Шүүгч, шүүхийн байгууллага нь засаглалын бусад эрх мэдэл, улс төрчид, албан тушаалтны нөлөөнд өртдөг гэх хандлага байна. ШУА-ын судалгаагаар шүүхийн шийдвэрт албан тушаалтан нөлөөлдөг гэж 2005 онд судалгаанд хамрагдсан иргэдийн 68 хувь нь үзэж байсан бол 2008 онд 75 хувь болж өссөн байна. 2009 онд Нээлттэй нийгэм форумын захиалгаар АНУ-ын Аризонагийн их сургуулийн эрдэмтэн Б.Вайтын судалгаагаар “Шүүгч шийдвэр гаргахдаа ямар нэгэн зүй бус нөлөөнд автдаггүй” гэдэгтэй 77 хувь нь санал нийлэхгүй байна. Олон улсын судалгааны “Херитэйж фаундэйшн” байгууллагын 2015 оны тайланд “Шүүх эрх мэдэл бие даасан боловч улс төрийн нөлөөнд өртөмтгий” байгааг дурдсан байна.

Мөн 2017-2019 онуудад хийгдсэн “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгаагаар шүүхийн шинэтгэлд цаашид тулгарч буй сорилтод эхний 3н байрт “Шүүгч хараат бусаар ажиллах баталгааг бүрдүүлэх” гэж судалгаанд оролцсон хүмүүсийн 39.1 хувь нь авч үзсэн. Иймээс шүүх, шүүгчийн аюулгүй байдал, хараат бусаар ажиллах баталгааг улам боловсронгуй болгох нь шүүхийн шинэтгэлийг цаашид үргэлжүүлэхэд нэн тэргүүний зорилт хэвээр байна.

- ❖ Шүүх эрх мэдлийн хараат бус байдал нь төсөв мөнгөний хүрэлцээ, шүүгчдийн цалин,

орлого бусад хангамжийн асуудалтай холбоотой гэж дүгнэж байна. ШУА-ын ФСЭХ-ийн судалгаагаар шүүх эдийн засаг санхүүгийн хараат байдалтай байна гэж дүгнэсэн байна. Нээлттэй нийгэм форум, Б.Вайтын судалгаагаар шүүгчийн цалинг 1000-3000 долларын хооронд шүүгчийн цалинг хөдөлмөр, зүтгэлээр нь тогтоож байх, хуулиар шүүгчийн цалинг зүй бус үйлдэл гаргасан үндэслэлээр үндсэн цалинг нь бууруулахаас бусад ямар ч тохиолдолд багасгахгүй байх, шүүгчийн цалин хамгийн шилдэг хуульчдыг татахуйц байх, шүүгч авлигад автан ажлаа эрсдэлд орохоос зайлсхийж байх ёстой гэсэн зөвлөмж боловсруулсан байна. Авлигатай тэмцэх газрын 2012 оны судалгааны тайланд “Шүүх хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахын тулд албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэдгийг дурдсан байна.

Иймээс шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн нэг чухал алхам болох шүүгчдийн цалинг нэмэгдүүлсэн байдлыг цаашид хадгалах, хамгаалах нь шүүгчийг хараат бусаар ажиллах баталгааны нэг багана гэж үзэж болохоор байна.

Гэхдээ 2018 онд Азийн сангаас хийсэн судалгаанд Шүүгчид хэргийн холбогдогч иргэн, өмгөөлөгч, прокуророос ирэх зохисгүй, зүй бус байдал, шууд ба шууд бус хэлбэрийн хөндлөнгийн нөлөөлөл их байна. Ялангуяа шүүгчид бусад шүүгчийн зүгээс нөлөөлсөн 16 тохиолдол, шууд тушаасан, үүрэг даалгавар өгсөн 6 тохиолдол, хамт ажиллагсад, удирдах албан тушаалтнаар дамжуулан нөлөөлөхийг оролдсон 7 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь анхаарал хандуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хориглосон шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцсон тохиолдол гарч байгаа нь шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, нөлөөлсөн этгээдэд хариуцлага тооцох, хариуцлагын механизмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

- ❖ Шүүхийн байгууллага авлигын индексээр эерэг, сайжирсан байдал харагдаж байна. ШУА-ын ФСЭХ-ийн судалгаагаар шүүхийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэхэд “Авлига авах гээд байдаг” гэж хариулсан хариултын эзлэх хувь 2005 онд 0.1 хувь, 2008 онд 3.5 хувь байсан бол 2010 онд 11.6 болтол өссөн байна. Нээлттэй нийгэм форум, Б.Вайтын гүйцэтгэсэн судалгаагаар “Шүүхийн шийдвэр нь зохигчид эсвэл бусад сонирхогч талаас өгсөн бэлэг, сэлтийн нөлөөнд ордоггүй” гэдэгтэй 77 хувь нь санал нийлэхгүй байна. Авлигатай тэмцэх газрын судалгаагаар шүүх эрх мэдлийн салбар дахь авлигын түвшин буурсаар байна. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2013 онд 3.68 байсан бол 2014 онд 3.58 болж 0.1 функтээр буурсан гэж үзэж байна.

Транспэрэнси интернэшнл байгууллагын судалгаагаар Монгол улсын авлигын индекс 2013 онд 38 оноо, 2014 онд 39 оноогоор 80 дугаар байранд орж урагшилсан, 2017 онд 36 оноотой болж өмнөх оны үзүүлэлтээс 13 байраар ухарчээ.

Харин шүүх эрх мэдлийн үнэлгээ урагшилсан байна. Тодруулбал, авлигын төсөөллийн индексийн 13 эх сурвалжийн нэг болох "Bertelsmann Foundation Transformation Index"-ийн тайланд Монгол Улс 2015, 2016 онд 100 онооноос 36 оноо авч байсан бол 2017 онд 41 оноо авч урагшилсан байна. Шүүхийн нэр хүндийг илэрхийлэх чухал үзүүлэлт нь авлигын түвшин бөгөөд сүүлийн жилүүдэд авлигын түвшин буурсан байгаа боловч ерөнхий хүрээгээрээ буюу Монгол Улсын хэмжээнд авлигын индекс ухарсан үзүүлэлттэй байгаа учир авлигыг бууруулах бодлогыг улам эрчимжүүлэх шаардлагатай байна.

- ❖ Шүүхийн үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хангалтгүй байна.

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаагаар шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг 23 хувь нь “Сайн” авдаг, 59 хувь нь “Дунд” авдаг 18 хувь нь бага буюу тааруу авдаг гэж хариулснаас үзвэл шүүхийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хангалттай хүрэхгүй байна. ШУА-ийн ФСЭХ-ийн 2013 оны судалгаанд шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй өөрчлөлтүүдийн талаар үнэлгээнд 2.5 хувь нь “Сайн мэднэ”, 14.7 хувь нь “Ерөнхийд нь мэднэ” 39.8 хувь нь “Дуулсан сайн мэдэхгүй”, 43 хувь нь Ер нь мэдэхгүй юм байна” гэж хариулсан байна. Шүүхийн шинэчлэлтийн хүрээнд хийгдэж буй ажлуудын талаар иргэд ерөнхийдөө хариулж мэдэхгүй байна. Ард иргэдийн дунд шүүхийн шинэчлэлтийн хүрээнд хийгдэж буй ажлуудыг хүртээмжтэй байдлаар хүргэх хэрэгтэй байгааг тус хүрээлэнгийн тайланд дурдсан байна.

- ❖ Шүүхийн шинэтгэл иргэдэд хүрч байна. 2017 онд хийгдсэн “Шүүх эрх мэдэл” судалгаанд иргэдийн 47.4 хувьд шүүх шинэчлэгдэн сайжирч байгааг мэдэрсэн гэсэн хариулт өгснөөс үзвэл шүүхийн шинэтгэл бодитой үр дүнд хүрснийг иргэдийн тал хувь нь шууд хүлээн зөвшөөрч байна гэж үзэж болохоор байна.

Мөн иргэд шинэтгэл ерөнхийдөө мэдрэгдэж байна, эвлэрүүлэн зуучлал үр дүнтэй хэрэгжиж байгаа, шүүхийн үйлчилгээ өмнөхөөсөө мэдэгдэхүйц сайжирсан гэдэгтэй хамгийн их санал нийлжээ. Түүнчлэн шүүхийн үйлчилгээнд цахим инноваци нэвтэрсэн, шүүхийн шийдвэр нээлттэй, үйл ажиллагаа нь ил тод болсон гэдэгтэй иргэдийн олонхи санал нийлжээ.

Харин шүүх бие даасан захиргаатай болсон, шүүхийн хараат бус байдал дээшилсэн, шүүхийн хүний нөөц шинэчлэгдэж байгаа, шүүх дагнаж, шүүгч мэргэшсэн зэрэг шинэтгэлийн өөрчлөлтүүд иргэдэд харьцангуй бага мэдрэгдсэн байна. Иймээс эдгээр чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг илтгэнэ.

Шүүгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай гэж иргэд үзэж байна. Судалгаанд оролцогчдийн 32.5 хувь шүүгчийн мэдлэг, чадварт эргэлздэг гээд цаашид шүүгчид сайн хүнийг томилох (45 хувь), шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх (40 хувь) шаардлагатай гэснээс үзэхэд манай улс мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоотойг сайжруулах, шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд шүүгч, ажилтнуудыг бэлтгэдэг, дадлагжуулдаг коллежтэй болох зэрэг шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлагатайг тус судалгаа өгүүлж байна.